

# AMAR

Үйлчилгээний танилцуулга  
Хэрэглэгчийн гарын авлага



*Одоо ч банкны үйлчилгээ **AMAR** болж гээ*

# ГАРЧИГ

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

АМАР гэж юу вэ?	03
Давуу талууд	04
Үйлчилгээнд бүртгүүлэх	05

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА

Анхаарах зүйлс	06
Дансны үлдэгдэл шалгах	07
Бэлэн бус төлбөр тооцоо хийх	08
Бэлэн орлогын гүйлгээ хийх	09
Бэлэн зарлагын гүйлгээ хийх	10
Сүүлийн 3 гүйлгээний мэдээлэл авах	11
Нууц код солих	12

## ХОЛБОО БАРИХ

Санал хүсэлт	13
--------------	----

# AMAR ГЭЖ ЮУ ВЭ?

ХасБанк танд гар утсаараа дамжуулан банкны үйлчилгээ авах маш AMAR-хан аргыг санал болгож байна.

Та үүрэн телефоны аль ч операторын хэрэглэгч байсан гар утасны сүлжээ орсон бүх сум, орон нутгаас ХасБанкин дахь дансаа хүссэн цагтаа, түргэн шуурхай, бага өртгөөр удирдах боломжийг AMAR үйлчилгээ танд олгоно.

## **Дараахь үйлчилгээг гар утсаараа дамжуулан авах боломжтой:**

- Дансны үлдэгдэл шалгах
- Дансанд хийгдсэн сүүлийн 3 гүйлгээний мэдээлэл авах
- Бэлэн бус шилжүүлэг хийх /данснаас данс руу/
- Дансандаа орлого хийх
- Данснаасаа бэлнээр зарлага гаргах
- Хувь хүний нэрээр мөнгөн гуйвуулга илгээх
- Төлбөр төлөх
- Нууц код солих

# ДАВУУ ТАЛУУД

Гэр бүл, найз нөхөд, бизнесийн түншүүдтэйгээ байнгын холбоотой байх, өөртөө цаг гаргаж, хайртай хүмүүстээ анхаарал тавих таатай боломж юм.

Хүссэн хүн рүүгээ, хүссэн үедээ гар утасных нь дугаараар мөнгө шилжүүлж, хүлээн авна гээд төсөөлдөө!

## **Дараахь үйлчилгээг гар утсаараа дамжуулан авах боломжтой:**

- **ЭРСДЭЛГҮЙ** – Бэлэн мөнгө биедээ авч явах шаардлагагүй
- **НАЙДВАРТАЙ** – Бүх гүйлгээ зөвхөн таны мэдэх нууц кодоор баталгааждаг. Гар утсаа хаяж, үрэгдүүлсэн, бусдад алдсан ч санаа зовох хэрэггүй.
- **ХУРДАН** – Хүссэн үедээ, гар утасны сүлжээ орсон хүссэн газраасаа санхүүгийн үйлчилгээ авах боломж.
- **ХЯЛБАР** – Дансны дугаар цээжлэх шаардлагагүй, энгийн, ойлгомжтой текст мессеж ашигладаг.
- **ХЯМД** – банк руу явж зардал гаргах шаардлагагүй, гэртээ, ажил дээрээ, хаанаас ч хамгийн бага зардлаар.
- **НЭМЭЛТ БОЛОМЖ** – Төрөл бүрийн урамшуулал, ХасБанкны бусад үйлчилгээнд хамрагдах, дансандаа өндөр хүү бодуулах, санхүүгийн түүх үүсгэх.

# ҮЙЛЧИЛГЭЭНД БҮРТГҮҮЛЭХ

## ▪ AMAR үйлчилгээнд бүртгүүлэх

Хэрэв та ХасБанкинд харилцах эсвэл хугацаагүй хадгаламжийн данс эзэмшдэг бол өөрийн данс байрлах манай банкны салбарт иргэний үнэмлэхтэйгээ очин, гар утсаа данстайгаа холбуулна.

## ▪ AMAR үйлчилгээнд хэрхэн бүртгүүлэх вэ?

Хэрэв та ХасБанкинд харилцах эсвэл хугацаагүй хадгаламжийн данс эзэмшдэг бол өөрийн данс байршдаг салбарт иргэний үнэмлэхтэйгээ очин бүртгүүлнэ.

Хэрэв таны амьдардаг орон нутагч ХасБанкны салбар ойрхон байхгүй бол Монгол Шуудан ТӨХК-ны өөрт аль ойр байрлах салбарт хандан үйлчилгээний эрх нээлгэж болно.

## ▪ Банкинд заавал данс эзэмшдэг байх уу?

Тийм. Та AMAR үйлчилгээнд бүртгүүлэхийн тулд ХасБанкинд харилцах эсвэл хугацаагүй хадгаламжийн дансны аль нэгийг эзэмшдэг байх ёстой.

## ▪ ААН, байгууллага үйлчилгээ авч болох уу?

Боломжгүй. Үйлчилгээнд зөвхөн иргэд бүртгүүлэх бөгөөд ААН, байгууллагууд АГЕНТ-аар Банктай хамтран ажиллах боломжтой

## ▪ Гүйлгээ хийхэд мөнгөн дүнгийн хязгаартай юу?

Зөвхөн бэлэн бус шилжүүлгийн гүйлгээнд хязгаартай. Нэг удаа 100,000төг Өдөрт 500,000төг

## ▪ Банкинд данс эзэмшдэггүй хүн рүү мөнгө шилжүүлж болох уу?

Болно. Та мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан хувь хүний нэрээр мөнгө гуйвуулах боломжтой.

## ▪ Яаж дансандаа бэлэн орлого, зарлага гүйлгээ хийх вэ?

ХасБанк нь энэхүү үйлчилгээнд улс даяар тархсан агентуудын сүлжээг ашигладаг бөгөөд та эдгээр агентуудад аль нэгд нь хандан бэлэн мөнгөний гүйлгээ хийх боломжтой.

# ГАРЫН АВЛАГА

Харилцагч та 131888 дугаарт хүсэлтээ мессежээр илгээснээр хэзээ ч хаанаас ч гар утаснаасаа төлбөр тооцоогоо хийх боломжтой.

Та мобайл банкны AMAR үйлчилгээнд бүртгүүлсэн харилцах эсвэл хугацаагүй хадгаламжийн данснаасаа дараах үйлчилгээг авна:

1. Дансны үлдэгдэл шалгах
2. Бэлэн бус төлбөр тооцоо гүйцэтгэх
3. Бэлнээр орлогын гүйлгээ хийх
4. Бэлнээр зарлагын гүйлгээ хийх
5. Дансанд хийгдсэн сүүлийн 3 гүйлгээний мэдээлэл авах боломжтой.
6. Нууц код солих

Танд дансандаа бэлнээр орлого, зарлагын гүйлгээ хийх хэрэгцээ гарсан нөхцөлд ХасБанкны салбар, тооцооны төвд ирэлгүйгээр, өөрт ойрхон байрлах АГЕНТ-аар үйлчлүүлэх боломжтой.

# АНХААРАХ ЗҮЙЛС

Та мобайл банкны АМАР үйлчилгээнд бүртгүүлэхдээ **НУУЦ КОД**-оо банкнаас авсан эсэхээ шалгаарай.

**Нууц код** гэдэг нь дансны үлдэгдэл шалгах, сүүлийн 3 гүйлгээний мэдээлэл авах, бэлэн бус гүйлгээ хийхэд хэрэглэгдэх 4 оронтой тоо юм.

**Та гар утаснаасаа нууц кодоо солих** боломжтой бөгөөд эрсдлээс сэргийлэх үүднээс нууц кодоо бусдад мэдэгдэхгүй чанд хадгална уу.

**Гар утсаа гэсэн тохиолдолд** үйлчилгээнд бүртгүүлсэн данс тань таны утасны дугаартай холбогдсон тул ХасБанкны 131888 дугаарт залгах буюу өөрт хамгийн ойр байрших салбар, тооцооны төвд хандан үйлчилгээний эрхээ түр хаалгаарай.

**АМАР үйлчилгээний цагийн хуваарь** - Үйлчилгээг ашиглан та Даваа-Баасан гарагийн 20:00-23:00, Бямба гарагийн 17:30-19:00, Ням гарагийн 16:30-18:00-аас бусад цагуудад гүйлгээ хийх боломжтой.

**Мэдээллээ нууцлах** - Та гүйлгээний хүсэлт, нууц код зэрэг мэдээллээ нууцлах үүднээс гар утасныхаа Inbox, Sent item дахь мессежээ устгаж байна уу.

# ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ ШАЛГАХ

Та мобайл банкны АМАР үйлчилгээнд бүртгүүлсэн дансныхаа тухайн агшин дахь үлдэгдлийг шалгахыг хүсвэл дараахь мессежийг 131888 тусгай дугаарт илгээнэ.

1. Гар утасны мессеж бичих талбарт Uldegdel гэж бичээд зай авч НУУЦ КОД-оо бичнэ.



131888 руу илгээнэ.

2. Мессежийг илгээхэд тухайн агшин дахь таны дансны үлдэгдлийн талаарх мэдээлэл ирнэ.



# БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ

Бэлэн бус төлбөр тооцоо буюу данснаас данс руу шилжүүлэг хийх, бараа үйлчилгээний төлбөрийг бэлэн бусаар төлөхийн тулд хүлээн авагч болон шилжүүлэгч нь хоёулаа AMAR үйлчилгээнд бүртгүүлсэн байх хэрэгтэй.

Бэлэн бус гүйлгээ нь тухайн агшинд шууд хийгдэх тул та төлбөр хүлээн авагчийн утасны дугаар, мөнгөн дүн зэргийг сайтар хянасны дараа гүйлгээг баталгаажуулна уу.

1. Гар утасны мессеж бичих талбарт Shiljuul гэж бичээд зай авч шилжүүлэх МӨНГӨН ДҮНГ бичин зай авч дансны валютын төрлийг MNT гэж бичин зай авч хүлээн авагчийн УТАСНЫ ДУГААР-ЫГ бичээд зай авч НУУЦ КОД-оо бичнэ.



131888 руу илгээнэ.


2. Мессежийг илгээсний дараа гүйлгээг баталгаажуулах тухай мессеж Банкнаас ирнэ.



3. Гүйлгээг баталгаажуулахын тулд мессежээр ирсэн 3 үсгийг бичиж буцаан илгээнэ.



4. Гүйлгээ амжилттай хийсэн тухай болон гүйлгээ хийсний дараахь байдлаар таны дансны үлдэгдлийн мэдээллийг ирүүлнэ.



# БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ

5. Гүйлгээ хийгдсэний дараа Банк хүлээн авагчийн дансанд орлого орсон тухай мэдээллийг илгээнэ.



**!** Банк үйлчилгээний нөхцөлийн дагуу таны данснаас бэлэн бус гүйлгээний хураамжийг суутгана.

Гүйлгээ баталгаажуулах код нь 20 минутын дотор ашиглаагүй тохиолдолд автоматаар устахыг анхаарна уу.

Хэрэв таны гүйлгээ баталгаажуулах код утсан бол 1-р алхамаас дахин эхлэх шаардлагатай.

# БЭЛЭН ОРЛОГЫН ГҮЙЛГЭЭ ХИЙХ


Банкны салбар хаасан эсхүл ойр орчинд байхгүй тохиолдолд та банктай хамтран ажиллаж буй АГЕНТ (AMAR агент гэсэн хаяг бүхий худалдаа үйлчилгээний газар)-аар дамжуулан ХасБанкинд байрших дансандаа бэлэн мөнгө хийх боломжтой.

1. Гар утасны мессеж бичих талбарт Orlogo гэж бичээд зай авч МӨНГӨН ДҮНГ оруулан зай авч дансны валютын төрлийг MNT гэж бичнэ.



131888 руу илгээнэ.

2. Банк мессежийг хүлээн авч шалгасны дараа танд ГҮЙЛГЭЭНИЙ КОД-ыг ирүүлнэ.



3. Та ГҮЙЛГЭЭНИЙ КОД, МӨНГӨН ДҮН-гээ өөрт ойрхон байрлах АГЕНТ-д өгч гүйлгээг хийнэ.

4. Агент өөрийн гар утаснаас таны гүйлгээний кодыг илгээж, баталгаажуулсны дараа танд таны дансны үлдэгдэл болон агентад бэлэн мөнгөө өгөх тухай мессеж ирнэ.



Энд хэлж буй үлдэгдэл нь таны орлогын гүйлгээ хийсний дараахь үлдэгдэл юм.

5. Бэлэн мөнгөө агентад өгч баримт авна.

**!** **Агентаар үйлчлүүлэхдээ иргэний үнэмлэхээ авч очно уу.**

Гүйлгээний код нь 2 цагийн дотор ашиглаагүй тохиолдолд автоматаар устгахыг анхаарна уу.

Хэрэв таны гүйлгээний код утсан бол 1-р алхамаас дахин эхлэх шаардлагатай.

# БЭЛЭН ЗАРЛАГЫН ГҮЙЛГЭЭ

Бэлэн орлогын гүйлгээний нэгэн адил банкны салбар хаасан эсхүл ойр орчинд байхгүй тохиолдолд та банктai хамтран ажиллаж буй АГЕНТ –аар дамжуулан ХасБанкинд байрших данснаасаа бэлэн мөнгө авах боломжтой.

1. Гар утасны мессеж бичих талбарт Zarlaga гэж бичээд зай авч МӨНГӨН ДҮНГ оруулан зай авч дансны валютын төрлийг MNT гэж бичнэ.



131888 руу илгээнэ.

2. Банк мессежийг хүлээн авч шалгасны дараа танд ГҮЙЛГЭЭНИЙ КОД-ыг ирүүлнэ.



3. Та ГҮЙЛГЭЭНИЙ КОД, МӨНГӨН ДҮН-гээ өөрт ойрхон байрлах АГЕНТ-д өгч гүйлгээг хийнэ.

4. Агент өөрийн гар утаснаас таны гүйлгээний кодыг илгээсний дараа танд ГҮЙЛГЭЭ БАТАЛГААЖУУЛАХ КОД ирнэ.



5. БАТАЛГААЖУУЛАХ КОД-ыг илгээснээр таны данснаас зарлагын гүйлгээ хийгдэнэ.



131888 руу илгээнэ.

# БЭЛЭН ЗАРЛАГЫН ГҮЙЛГЭЭ

6. Гүйлгээ хийгдсэн тул агентаас бэлэн мөнгө авах тухай мессеж ирнэ.



7. Бэлэн мөнгө болон гүйлгээний хураамжийг агентад өгч баримт авна.

 **Агентаар үйлчлүүлдээ иргэний үнэмлэхээ авч очно уу.**

# СҮҮЛИЙН 3 ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ


Та AMAR үйлчилгээнд бүртгүүлсэн данснаасаа хийсэн сүүлийн 3 гүйлгээний мэдээллийг авах боломжтой.

1. Гар утасны мессеж бичих талбарт Huulga гэж бичээд зай авч НУУЦ КОД –ыг бичнэ.



131888 руу илгээнэ.


2. Таны дансанд хамгийн сүүлд хийгдсэн гурван гүйлгээний мэдээллийг харуулна.



Сүүлийн 3 гүйлгээний мэдээлэл нь таны ХасБанкны салбар, тооцооны төвд ирж хийсэн болон гар утас, интернет ашиглан хийсэн бүх төрлийн гүйлгээний мэдээллийг харуулна.


# НУУЦ КОД СОЛИХ

1. Гар утасны мессеж бичих талбарт Nuuts kod гэж бичээд зай авч ХУУЧИН НУУЦ КОД –ыг бичиж, зай авч ШИНЭ НУУЦ КОД –ыг бичнэ.




131888 руу илгээнэ.

2. Танд банкнаас шинэ нууц кодоо баталгаажуулж дахин оруулах тухай мессеж ирнэ.



3. ШИНЭ НУУЦ КОД –ыг дахин бичиж илгээнэ.



4. Нууц код солигдсон тухай мэдээлэл ирнэ.



# АМАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ

Үйлчилгээний төрөл	Үнэ /төгрөгөөр/	
	Жи мобайл, Скайтел, Юнителийн хэрэглэгч бол	Мобикомын хэрэглэгч бол
Үйлчилгээний эрх нээх	Хураамжгүй	
Бэлэн зарлагын гүйлгээний шимтгэл	100	150
Бэлэн бус гүйлгээний шимтгэл	150	200
Мөнгөн гуйвуулга илгээх	650	
Нэг удаагийн гүйлгээний хязгаар	100 ,000	
Нэг өдрийн гүйлгээний хязгаар	500 ,000	

Харилцагчийн үүрэн телефоны оператор компанид төлөх 1 мессежийн үнэ:  
 Жи мобайл, Скайтел, Юнителийн хэрэглэгчид - 20 төг  
 Мобикомын хэрэглэгчид - 40 төг

# ХАРИЛЦАГЧААС ИЛГЭЭХ МЕССЕЖИЙН ЗАГВАР

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ	МЕССЕЖ
Үлдэгдэл шалгах	uldegdel 1234 (нууц код)
Бэлэн бус гүйлгээ хийх	shiljuul 10000 (мөнгөн дүн) mnt 91201010 (хүлээн авагчийн утасны дугаар) 1234 (нууц код)
Бэлэн орлого	Orlogo 10000 (мөнгөн дүн) mnt
Бэлэн зарлага	Zarlaga 10000 (мөнгөн дүн) mnt
Сүүлийн 3 гүйлгээний мэдээлэл авах	huulga 1234 (нууц код)
Нууц код солих	nuuts kod 1234 (хуучин нууц код) 5678 (шинэ нууц код)

# ТУСЛАМЖ, САНАЛ, ХҮСЭЛТ

Та AMAR үйлчилгээтэй холбоотой мэдээллийг [www.amar.mn](http://www.amar.mn) хаягаар, үйлчилгээтэй холбоотой тусламж авах, эсвэл өөрийн санал, сэтгэгдлээ илэрхийлэхийг хүсвэл дараахь хаягаар хандана уу.

1. Харилцагчийн үйлчилгээний төв 1888 (энгийн утасны тарифаар) дугаар;
2. Өөрт хамгийн ойр байрлах ХасБанкны салбар;
3. Цахим шуудангийн [ebd@hasbank.mn](mailto:ebd@hasbank.mn) хаяг;

Бид Таны санал сэтгэгдлийг хүлээж авахдаа байнга баяртай байх болно.